

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20..оны... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ**

1 дүгээр зүйл.

1.1.Энэ хуулийг баталсанаар тусгай зөвшөөрөлд хамаарах үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээд хуульд заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, тусгай зөвшөөрөл шинэчлэн авах хүсэлтээ хууль хэрэгжиж эхэлснээс хойш 6 сарын дотор тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд гаргана.

1.2.Энэ хуулийн 1.1-т заасан хугацаанд тусгай зөвшөөрөл шинэчлэн аваагүй эсхүл эрх бүхий этгээдэд тусгай зөвшөөрөл шинэчлэн авах хүсэлтээ зохих ёсоор гаргаагүй этгээдийн тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг хүчингүйд тооцно.

2 дугаар зүйл.

2.1.Энэ хуулийг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20..оны... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖИЛЛАХ ХҮЧ ГАДААДАД ГАРГАХ, ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ,
МЭРГЭЖИЛТЭН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.2001 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.13 дугаар зүйлийг дор дурьдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.13 дугаар зүйл.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль зөрчих

1.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр хууль бус хөдөлмөр эрхлүүлсэн бол гадаадын иргэн, харьяалалгүй хүний хөдөлмөр эрхэлсэн хугацааны гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг нөхөн төлүүлж, хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

Тайлбар: “хууль бус хөдөлмөр эрхлэлт” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд тодорхойлсон хөдөлмөрийн харилцаанд оролцож, ашиг, орлого олох зорилготой эсэхээс үл хамааран, энэ хуульд заасан зөвшөөрөлгүйгээр гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр ажил гүйцэтгүүлсэн, хөлсөөр ажиллуулсан, туслан гүйцэтгүүлсэн бүх төрлийн хөдөлмөр эрхлэлт, тэдгээрийг хөдөлмөр эрхлүүлнэ гэж ухуулан сурталчилсан, элсүүлсэн, тээвэрлэсэн үйлдлийг.

2.Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг төлөөгүй бол гадаадын иргэн, харьяалалгүй хүний тухайн ажил олгогчид хөдөлмөр эрхэлсэн хугацааны төлбөрийг нөхөн төлүүлж, хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

3.Гадаад ажилтныг хөдөлмөрийн чиг баримжаа олгох сургалтад хамруулаагүй, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах үүргээ биелүүлээгүй хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

4.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан гадаадын ажилтныг нутаг буцаах үүргээ биелүүлээгүй бол гадаадын ажилтны ажлын байрны төлбөрийг нөхөн төлүүлж, хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах эрх бүхий байгууллагын хяналт шалгалтын үйл ажиллагаанд саад учруулсан, шалгуулахаас татгалзсан, хууран мэхэлсэн бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

6.Гадаадын иргэнийг зохих зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхлүүлсэн ажил олгогчид гадаадын иргэн, харьяалалгүй хүний хөдөлмөр эрхэлсэн хугацааны гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг нөхөн төлүүлж, хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучилсан иргэний бүртгэл хөтлөөгүй, мэдээ, тайланг тогтоосон хугацаанд өгөөгүй, хуурамч тайлан

өгсөн бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

8.Тусгай зөвшөөрөл эзэмшигч зуучлах ажлын байранд хуулиар зөвшөөрснөөс олон иргэнийг бүртгэсэн, зуучлуулагчтай зуучлалын гэрээ байгуулаагүй, зуучлуулагчаас хууль бусаар төлбөр хураамж, бэлэн мөнгө авсан бол хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

9.Тусгай зөвшөөрөл эзэмшигч Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нэг мянгаас гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

10.Ашиг, орлого олох зорилготой эсэхээс үл хамааран зөвшөөрөлгүйгээр иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучилсан, хөдөлмөр эрхлүүлнэ гэж ухуулан сурталчилсан, элсүүлсэн нь гэмт хэргийн шинжгүй бол учруулсан хохирлыг нөхөн төлүүлж хүнийг найман арван мянган нэгжтэй, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэн хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.4 дэх хэсгийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон, Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 5.1.46 дахь заалт нэмсүгэй:

“5.1.46. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд заасан гадаадын ажиллах хүчний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үйлчилгээ;”

2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 24.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“24.1. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, үйлчилгээ үзүүлэхэд доор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

24.1.1. гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 3 000 000-5 000 000 төгрөг;

24.1.2. гадаад ажилтан авахад зуучлах тусгай зөвшөөрөл олгоход 3 200 000-8 000 000 төгрөг;

24.1.2. гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад 1 000 000-3 000 000 төгрөг;

24.1.3. гадаадаас ажилтан авах үйлчилгээ (гадаад ажилтан авч ажиллуулах урилга олгох, зөвшөөрөл олгох, сунгах, шилжүүлэх, хасалт, тодорхойлолт, лавлагаа) үзүүлэхэд хүн тутамд 15 000-25 000 төгрөг;

3 дугаар зүйл. Энэ хуулийг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон, Улаанбаатар
хот

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлд дурьдсан агуулгатай 23.6 дахь хэсэг нэмсүгэй:

“23.6. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 38.7-д заасан ажлын байрны төлбөр төлөх, буцаан авах талаархи харилцааг зохицуулсан журмыг Засгийн газраас батална.”

2 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 2.1 дэх хэсэг болон 26.8.1 дэх заалтын “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” гэснийг “Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.9 дэх заалтын “Гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн ажлын байр бий болговол түүнд бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлж, энэ хуулийн 12.3, 12.4-т заасан зээл, хөнгөлөлт үзүүлж болно” гэснийг “хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусгавар болсоноор эх орондоо буцан ирсэний дараа дасан зохицох, ажлын байр бий болгох, жижиг дунд үйлдвэр байгуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээл, бусад хөнгөлөлт үзүүлнэ.” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8.7 дахь заалтын “гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөрийн хэмжээг тогтоох” гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон, Улаанбаатар
хот

**ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.2 дах хэсгийн “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” гэснийг “Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон, Улаанбаатар
хот

ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дипломат албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дахь хэсэгт дор дурьдсан агуулгатай 5.1.15 дахь заалт нэмсүгэй.

“5.1.15.ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөний мэдээллээр хангах;”

2 дугаар зүйл. Дипломат албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт дор урьдсан агуулгатай 7 дахь хэсэгт “амьдарч буй” гэсний ард “хөдөлмөр эрхэлж буй” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Дипломат албаны тухай хуулийн 5.1.15 дахь заалтын дугаарыг 5.1.16 болгон өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон, Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт дор дурьдсан агуулгатай 20 дахь заалт нэмсүгэй.

“38.1.20. “Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн дагуу гадаад улсад хөдөлмөр эрхэлж, үйлдвэрлэлд дадлагажин, эх орондоо буцан ирж буй Монгол Улсын иргэний үйлдвэрлэлийн зориулалтай машин, тоног төхөөрөмж, хөдөлмөрийн багаж хэрэгсэл, өөрийн болон гэр бүлийн ахуйн хэрэгцээний эд зүйлс”

2 дугаар зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “38.1.19-д” гэснийг “38.1.19, 38.1.20-д” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон, Улаанбаатар
хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11 дэх заалтад “ эрдэм шинжилгээний байгууллага” гэсний ард “сургалтын төв” гэж, “бүртгэлд хамруулах” гэсний ард “хяналт тавих, холбогдох журмыг баталж мөрдүүлэх” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон, Улаанбаатар
хот

ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Чөлөөт бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.4 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Чөлөөт бүсийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 хэсгийн дугаарыг “15.1”, 15 дугаар зүйлийн 15.3 хэсгийн дугаарыг “15.2” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ